

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 03 сарын 12 өдөр

№ 25/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1, 9.2 дэх хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 10-р зүйлийн 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 21-ны өдрийн 10:00 цагаас Хөрөнгө оруулалтын сангийн Нэгж эрх эзэмшигчдийн албан ёсны фэйсбүүк групп болох **Mandal Ireeduin Osolt ХОС Мандал Ирээдүйн Өсөлт ХОС** (линк: <https://www.facebook.com/groups/303072678240799>) группээр зарлан **ХУРАЛДУУЛСУГАЙ.**
- Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуулгыг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) сайтаар, мөн саналын хуудсаар тус тус дамжуулан **ХЭРЭГЖҮҮЛСҮГЭЙ.**
- Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг **ХЭЛЭЛЦҮҮЛСҮГЭЙ.** Үүнд:
  - Сангийн 2024 үйл ажиллагааны тайланг танилцуулах;
  - Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг батлах;
  - Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг батлах;
  - Сангийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
  - Сангийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
  - Сангийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай;
  - ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай;
  - ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай;
  - Сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
  - Сангийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

4. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой нэгж эрх эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг **Хавсралт №4**-р, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **Хавсралт №5**-р, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загвар, Итгэмжлэл олгох гэрээг **Хавсралт №6**-р тус тус **БАТАЛСУГАЙ**.
5. Хуралд оролцох эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2025 оны 04 сарын 01**-ний өдрөөр **ТОГТООСУГАЙ**.
6. Хурлын зарыг **2025 оны 03 сарын 17, 2025 оны 03 сарын 27**-ний өдрүүдэд **өдөр тутмын сонин болон менежментийн компанийн [www.mandalasset.mn](http://www.mandalasset.mn)** цахим хуудсаар тус тус дамжуулан нэгж эрх эзэмшигчдэд **МЭДЭЭЛСҮГЭЙ**.
7. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн нэгж эрх эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь **2025 оны 04-р сарын 18-ны** өдрийн 16 цаг 00 минут хүртэл байна.
8. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан **2025 оны 03-р сарын 17**-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд нэгж эрх эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын **Хавсралт №1** болон **Хавсралт №2** дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр **2025 оны 03-р сарын 21**-ны өдөр нэгж эрх эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
10. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар **Ганболд овогтой Батзоригийг ТОМИЛСУГАЙ**.
11. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга **Ууганбаатар овогтой Сансармаад ДААЛГАСУГАЙ**.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



В. АМАРЖАРГАЛ

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” (цаашид “Сан” гэх)-ийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх) нь Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 21-ны өдрийн 10:00 цагаас Хөрөнгө оруулалтын сангийн Нэгж эрх эзэмшигчдийн албан ёсны фэйсбүүк групп болох **Mandal Ireeduin Osolt ХОС** | **Мандал Ирээдүйн Өсөлт ХОС** (линк: <https://www.facebook.com/groups/303072678240799>) группт цахим хэлбэрээр хуралдах тул Нэгж эрх эзэмшигч та бүхэн идэвхтэй хуралдаа оролцоорой.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэнэ. Үүнд:

- 1.1. Сангийн 2024 үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- 1.2. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг батлах;
- 1.3. Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг батлах;
- 1.4. Сангийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 1.5. Сангийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
- 1.6. Сангийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 1.7. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай;
- 1.8. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай;
- 1.9. ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай;
- 1.10. Сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- 1.11. Сангийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

Ээлжит хуралд оролцох эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь **2025 оны 04-р сарын 01-ний өдөр** (цаашид “Бүртгэлийн өдөр” гэх) байна.

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон нэгж эрх эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон нэгж эрх эзэмшигч нь Ээлжит хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян-Гүний гудамж Мэрү тауэр 602 тоот хаягаар, тооллогын комиссоор дамжуулан Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар урьдчилан өгөх боломжтой.

Хэрэв нэгж эрх эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцогч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гүйцэтгэх захирал биш бол хуулийн этгээдээс олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлийг заавал авчрах шаардлагатай.

Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа **2025 оны 04-р сарын 18-ны өдрийн 16 цаг 00 минут** хүртэл байна.

Ээлжит хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

№	Комиссын гишүүдийн нэрс	Утасны дугаар	Шуудангийн хаяг
1.	А.Даваадорж	7575-9911	davaadorj@mandalasset.mn
2.	Г.Насанжаргал	7575-9911	nasanjargal@mandalasset.mn

**Ажиллах цагийн хуваарь:** Ажлын өдрүүдэд 09:00–17:00 цагийн хооронд ажиллана.

**Компанийн хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян-Гүний гудамж Мэрү тауэр, 6 давхарт, 602 тоот

**Имэйл:** [support@mandalasset.mn](mailto:support@mandalasset.mn)

**Утас:** 75759911

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ  
ХОЛБООТОЙ НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ  
БИЧГИЙН ЖАГСААЛТ**



Нэгж эрх эзэмшигчийн ээлжит хуралд оролцох нэгж эрх эзэмшигчид нь 2025 оны 04-р сарын 01-ний өдрөөс эхлэн 04-р сарын 18-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 17:00 цагийн хооронд “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээрээ очиж дараах баримт бичгүүдтэй танилцах боломжтой. Үүнд:

1. Хурлын зар;
2. Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа;
3. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн;
4. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол;
5. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн;
6. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
7. Сангийн 2024 үйл ажиллагааны тайлан;
8. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний 2024 оны жилийн тайлан;
9. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний 2024 оны жилийн тайлан;
10. Сангийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
11. Сангийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
12. Сангийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
13. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
14. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай;
15. Сангийн дүрэмд орох өөрчлөлтийг хэлэлцэн батлах;
16. Сангийн Нэгж эрхийн танилцуулгад орох өөрчлөлтийг хэлэлцэн батлах;
17. Тогтоолын төсөл;
18. Саналын хуудас;
19. Итгэмжлэлийн загвар, гэрээ



**САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР**

**САНАЛЫН ХУУДАС**

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Сангийн нэр: “Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК

Хурал хуралдах хэлбэр, огноо: 2025 оны 04-р сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минутаас Хөрөнгө оруулалтын сангийн Нэгж эрх эзэмшигчдийн албан ёсны фэйсбүүк групп болох **Mandal Ireeduin Osoit ХОС | Мандал Ирээдүйн Өсөлт ХОС** ([линк: https://www.facebook.com/groups/303072678240799](https://www.facebook.com/groups/303072678240799)) группт цахим фэйсбүүк хуудсаар цахим хэлбэрээр хуралдана.

Нэгж эрх эзэмшигчийн эцэг/эхийн нэр: ..... нэр .....

Нэгж эрх эзэмшигчийн дансны дугаар: .....

Регистрийн дугаар: .....

Эзэмшиж буй нэгж эрхийн тоо .....

№	Батлах асуудал: (Саналыг энгийн аргаар тоолно.)	Нэгж эрх эзэмшигчийн санал			Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	ХОМК болох “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг батлах				
2	Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах				
3	ХОС-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;				
4	ТУЗ-ийн 2025 үйл ажиллагааны зардлын төсөв батлах				
6	Сангийн дүрэмд хавсралтад заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулах тухай				
7	Сангийн нэгж эрхийн танилцуулгад хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулах тухай				
№	Батлах асуудал: (Саналыг кумулятив аргаар тоолно.)	Нэгж эрх эзэмшигчийн санал			Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай /ТУЗ-ийн гишүүд болох Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр/				
2	ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, шинээр томилох				

тухай /ТУЗ-ийн гишүүн Р.Амаржаргалыг чөлөөлж, нөхөн томлох тухай /				
---	--	--	--	--

Нэгж эрх эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): .....

Огноо: 2025 оны ..... -р сарын ..... -ны өдөр ..... цаг ..... минут

**САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ**

1. Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
  - Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (√) тэмдэг тавина.
  - Засварласан, балласан, (√)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг хувилбарыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
  - Нэгж эрх эзэмшигч хувь хүн бол уг саналын хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна, эсхүл итгэмжлэлээр төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.
2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян-Гүний гудамж Мэрү тауэр, 6 давхарт, 602 тоот хаягаар 2025 оны 04 сарын 18-ний өдрийн 16:00 цаг дотор ирүүлнэ үү.
3. Нэгж эрх эзэмшигч нь Нэгж эрх эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын даргын заавраар Тооллогын комисс-т өөрийн бөглөсөн саналын хуудсыг өгнө.
4. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг нэгж эрх эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

**Таныг төлөөлөх хүний**

Овог ..... нэр .....

**Таны:**

Овог ..... нэр .....

Утасны дугаар .....

Гарын үсэг .....

**Зөвхөн тооллогын комиссын албан хэрэгцээнд:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм /Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: .....

Саналын хуудас тоолсон өдөр, цаг: 2025 оны ..... сар ..... өдөр ..... цаг ..... минут



## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

*ХОС-ийн 2024 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгүүдийг тус тус удирдлага болгон “Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН  
ТӨСӨЛ**

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

*ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний  
жилийн тайланг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг ,  
Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь  
хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх  
эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Сангийн ХОМК болох “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн Хөрөнгө  
итгэмжлэн удирдах гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2024 оны жилийн  
тайланг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
нарийн бичгийн дарга У.Сансармаа-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ



**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН  
ТӨСӨЛ**

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

*Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний  
жилийн тайланг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны хэлтсийн хөрөнгө хадгалах үйлчилгээний 2024 оны жилийн тайланг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН  
ТӨСӨЛ**

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

*ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны  
зардлын төсөв батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх хэсэг, 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	Бичиг хэргийн зардал	2,000,000
2	ТУЗ-ийн хурлын зардал	3,000,000
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	10,000,000
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин /жилээр/	28,000,000
	<b>Нийт дүн</b>	<b>43,000,000</b>

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

*ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс саналыг кумулятив аргаар тоолсон болохыг тэмдэглэн, Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС /цаашид Сан гэх/-ийг үүсгэн байгуулах 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 21/009 тогтоолоор томилогдсон Сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болох Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр нарыг 5 жилийн хугацаатай улируулан сонгосугай.
2. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан улиран сонгогдож буй гишүүдийг олон нийтэд мэдээлэх, Зохицуулагч байгууллагуудад мэдэгдэхийг сангийн Гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

*ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 10.2, 10.3 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс саналыг кумулятив аргаар тоолсон болохыг тэмдэглэн, Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК /цаашид Сан гэх/-ийн Нэгж эрх эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 006 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр томилогдсон Р.Амаржаргалын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө буюу 2025 оны 04 сарын 21-ний өдрөөр дуусгавар болгосугай.
2. Сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Р.Амаржаргал үүрэгт ажлаас чөлөөлөгдөж байгаатай холбогдуулан Нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг 2025 оны 04 сарын 21-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаагаар томилсугай.
3. Шинээр томиогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг олон нийтэд мэдээлэх, Санхүүийн Зохицуулах Хороонд тохиромжтой этгээдээр тодорхойлуулах, холбогдох бичиг баримтыг хүргүүлэхийг сангийн Гүйцэтгэх удирдлага Ганзоригт даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН  
ТӨСӨЛ**

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

*Дүрэмд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15 дахь хэсэг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Сангийн дүрэмд энэхүү шийдвэрийн Хавсралт 1-т заасан өөрчлөлтийг оруулсугай.
2. Энэхүү шийдвэрийн 1-д заасны дагуу зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг Сангийн гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

## САНГИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

### I. Сангийн дүрмийн хэсэгт оруулах өөрчлөлт

Одоо байгаа хэсэг	Өөрчлөн найруулах
<b>1. Өөрчлөн найруулах</b>	
“Сангийн менежер”	“Сангийн гүйцэтгэх удирдлага”
<p>4.5 Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд: 4.5.1 Засгийн газрын, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл; 4.5.2 Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа; 4.5.3 Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл; 4.5.4 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;</p>	<p>4.5 Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд: 4.5.1 Засгийн газрын, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл; 4.5.2 Нээлттэй Монгол улсын болон гадаад улсы хувьцаат компанийн хувьцаа; 4.5.3 Монгол улсын болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаг компаний өрийн хэрэгсэл; 4.5.4 Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл; 4.5.5 Гадаад улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас 4.5.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас; 4.5.5. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх 4.5.6. Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад хэрэгсэл</p>
9.2 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компаний тухай хуулийн 62 дугаар зүйл нэгэн адил хамаарна.	9.2 Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос тогтоосон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад журамд заасан бүрэн эрхийг эдлэнэ.
9.3.5 Компаний тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос тогтоосон Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбосотой журмуудад заасан бусад асуудлыг шийдвэрлэх.	9.3.5 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, бусад хууль болон Хорооноос тогтоосон Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой журмуудад заасан бусад асуудлыг шийдвэрлэх.
10.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь гурван (3) жил байх бөгөөд улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүдийг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэдийд ч өөрчлөн сольж болох бөгөөд тэр тохиолдолд саналын эрх бүхий Сангийн нэгж эрх эзэмшигчдийн арван (10) буюу түүнээс дээш хувийн санал, шаардлага гаргаснаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.	10.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь таван (5) жил байх бөгөөд улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүдийг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэдийд ч өөрчлөн сольж болох бөгөөд тэр тохиолдолд саналын эрх бүхий Сангийн нэгж эрх эзэмшигчдийн арван (10) буюу түүнээс дээш хувийн санал, шаардлага гаргаснаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.
10.4.10 КомпанийнБ тухай хуулийн 11-р бүлэгт заасн их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох.	10.4.10 Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, /Энэхүү их хэмжээний хэлцэлд Компанийн тухай хуулийн 87.1. дэх хэсгийг ойлгоно
10.5 ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.	10.5 ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа танхим эсхүл цахим хэлбэрээр хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.

<b>2. Дүрмээс хасах</b>
4.7 Сан нь энэхүү Дүрэмд зааснаас өөр хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.
11.11.4 Хөрөнгө оруулалт хийх боломжтой байгаа хөрөнгийн талаар ТУЗ-д зөвлөх
15.1.9 Сангийн маркетингийн зардал
15.2 ХОМК-ийн Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах зардалд доорх хамаарна. / бүхлээр нь хассан/
<b>3. Дүрэмд нэмэх</b>
4.6 Сангийн активт энэхүү дүрмийн 4.5 дах хэсэгт заасан хөрөнгө оруулалтын хэрэгслээс гадна Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгсэл байж болно.
11.3.1 Гүйцэтгэх удирдлага нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн хугацаанд, эсхүл дараагийн гүйцэтгэх удирдлага томилогдох хүртэлх хугацаанд түүний эрхийг ХОМК-ийн гүйцэтгэх захирал, эсхүл Хороонд бүртгэлтэй хөрөнгө оруулалтын зөвлөх нь итгэмжлэлийн үндсэн дээр хэрэгжүүлж болно

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР БАТЛАХ ТОГТООЛЫН  
ТӨСӨЛ**

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

*Сангийн Нэгж эрхийн танилцуулгад  
өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Сангийн Нэгж эрхийн танилцуулгад энэхүү шийдвэрийн Хавсралт 1-т заасан өөрчлөлтийг оруулсугай.
2. Энэхүү шийдвэрийн 1-д заасны дагуу зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг Сангийн гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ



## **НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГАД ОРОХ ӨӨРЧЛӨЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

*Сангийн нэгж эрхийн танилцуулгын 3.2.3 дах хэсгийн “Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хязгаарлалт” хэсэгт орох өөрчлөлт*

Сан нь өөрийн хөрөнгөө доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Үүнд:

- Засгийн газрын, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй Монгол улсын болон гадаад улсы хувьцаат компанийн хувьцаа;
- Монгол улсын болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаг компаний өрийн хэрэгсэл;
- Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл;
- Гадаад улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;
- Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад хэрэгсэл;

Сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоодог бөгөөд Сан нь уг хууль, журмын шаардлагад нийцүүлэн ажиллана.

***Өмнөх Сангийн нэгж эрхийн танилцуулгын 3.2.3 дах хэсгийн “Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хязгаарлалт” хэсэг***

Сан нь өөрийн хөрөнгөө доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Үүнд:

- Засгийн газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
- Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- Санхүүгийн Зохицуулах Хороо болон нэгж эрх эзэмшигчдийн хурлаар зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгсэл.

Сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоодог бөгөөд Сан нь уг хууль, журмын шаардлагад нийцүүлэн ажиллана.



**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны 2024 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Зохион байгуулах комиссын дарга:	А.Даваадорж /хөрөнгө оруулагчтай харилцах албаны ахлах менежер/
Зохион байгуулах комиссын гишүүд:	Г.Насанжаргал /хөрөнгө оруулагчтай харилцах албаны менежер / Г.Төгсбилэг /Ахлах дата аналит / А.Цэлмүүн-Оюу /хөрөнгө оруулагчтай харилцах албаны менежер /

**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР**

Миний бие ..... -ны ..... (РД: ..... )  
нь “Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК (“Компани” гэх)-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө дэх нэг бүр нь .....  
төгрөгийн нэрлэсэн үнэтэй ..... ширхэг нэгж эрхийг эзэмшдэг бөгөөд энэхүү  
итгэмжлэлээр Сангийн хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэгч “Голомт банк” ХК (РД: 2075377) -г 2025 оны  
04 сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минутад болох “Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК-ийн нэгж эрх  
эзэмшигчдийн ээлжит хуралд миний нэрийн өмнөөс оролцох, нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын зард  
тусгасан хэлэлцэх асуудал болон хурлаас гарах шийдвэртэй холбогдуулан доор заасны дагуу, хэрэв доор  
тусгайлан тэмдэглээгүй/заагаагүй бол өөрийн зохистой гэж үзсэний дагуу санал өгөх бүрэн эрхийг олгож,  
итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж байна.

№	Батлах асуудал: (Саналыг энгийн аргаар тоолно.)	Нэгж эрх эзэмшигчийн санал			Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	ХОМК болох “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг батлах				
2	Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах				
3	ХОС-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;				
4	ТУЗ-ийн 2025 үйл ажиллагааны зардлын төсөв батлах				
6	Сангийн дүрэмд хавсралтад заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулах тухай				
7	Сангийн нэгж эрхийн танилцуулгад хавсралтад заасны дагуу өөрчлөлт орлуулах тухай				

№	Батлах асуудал: (Саналыг кумулятив аргаар тоолно.)	Нэгж эрх эзэмшигчийн санал			Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	
1	ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай /ТУЗ-ийн гишүүд болох Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр				
2	ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, шинээр томилох				

тухай /ТУЗ-ийн гишүүн Р.Амаржаргалыг чөлөөлж, нөхөн томилох тухай /				
--	--	--	--	--

Нэгж эрх эзэмшигчийн гарын үсэг, тэмдэг: .....

Итгэмжлэл олгосон огноо: .....

1. Нэгж эрх эзэмшигч өөрийн нэр, хаяг, регистрийн дугаарыг том үсгээр бичиж оруулна уу.
2. Нэгж эрх эзэмшигч өөрийн нэр дээр бүртгэлтэй, энэхүү итгэмжлэлд хамаарах нэгж эрхийн тоог оруулна уу. Хэрэв тодорхой тоо заагаагүй бол энэхүү итгэмжлэлийг таны нэр дээрх Компанийн бүх нэгж эрхэд хамааруулна.
3. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, регистрийн дугаарыг оруулна уу. Нэгээс илүү итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох бол тухайн итгэмжлэлд хамаарах нэгж эрхийн тоог оруулна уу. Хэрэв аливаа нэр заагаагүй бол Хурлын дарга таны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хуралд санал өгөх болно.
4. **АНХААР:** Энгийн аргаар санал тоолох асуудлын хувьд л холбогдох хэсгийн “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” -ий зөвхөн аль нэгийг (√) гэж тэмдэглэнэ үү. Саналыг кумулятив аргаар тоолох асуудлын хувьд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг дэмжиж байгаа тохиолдолд нэр дэвшигчид өгөх саналын тоо хэсэгт өөрийн эзэмшиж буй нийт саналын эрхийн тоог компанийн дүрэмд заасан ТУЗ-ийн нийт гишүүдийн тоо буюу 5-аар үржүүлсэн саналын эрхийн тоог тавина уу. Хэрвээ тус гишүүнийг сонгохоос татгалзаж байгаа тохиолдолд татгалзсан гэсэн хэсэгт (√) тэмдэглэгээг тавина. Аливаа тэмдэглэгээ хийгээгүй тохиолдолд таны итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн үзэмжээр Хурлаас гарах шийдвэрт санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу.
5. Нэгж эрх эзэмшигч хувь хүн бол уг итгэмжлэл дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн гарын үсэг зурж компанийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

“Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 1-р хороо, Жамьян-гүний гудамж, Meru Tower-н 6 давхарт 602 тоот

Утас: (976) 7575 9911

И-мэйл: [support@mandalasset.mn](mailto:support@mandalasset.mn)

Вэб хуудас: <https://mandalasset.mn/>

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 03 сарын 12 өдөр

№ 25/03

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Тооллогын комисс томилох тухай

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2024 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбоотойгоор Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2024 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй **БАЙГУУЛСУГАЙ.**

1.1. Комиссын дарга: С.Батбаяр /Санхүү хариуцсан захирал/  
1.2. Гишүүд: Г.Төгсбилэг /Ахлах дата аналитист/  
Б.Түвшинбаяр /Борлуулалтын ахлах менежер/  
Б.Хонгорзул /Бизнес хөгжлийн менежер/  
Б.Энхтуул /Хөрөнгө оруулалтын шинжээч/

2. Тооллогын комиссын дарга С.Батбаярт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг **ДААЛГАСУГАЙ.** Үүнд:

2.1 Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;  
2.2 Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;  
2.3 Санал өгөх журмыг тайлбарлах, нэгж эрх эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;  
2.4 Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;  
2.5 Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулах;  
2.6 Саналын хуудсыг сангийн архивд хадгалуулахаар шилжүүлэхийг тус тус үүрэг **БОЛГОСУГАЙ.**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Р. АМАРЖАРГАЛ